





“Вестник сельскохозяйственной науки” нь 1936 оны сүүлчээс Бүх холбоотын Хөдөө аж ахуйн Шинжлэх ухааны Академиас эрхлэн гаргадаг болсон сар тутмын эрдэм шинжилгээний сэтгүүл юм. Тус сэтгүүлд Хөдөө аж ахуйн шинжлэх ухаанд хамаарах бүхий л салбарын эрдэмтэдийн бичсэн судлал шинжлэл, ололт нээлт, тэдгээрийн үр дүнг өргөнөөр нийтлэдэг юм. Тус сэтгүүлийн 1957 оны нэгдүгээрт газар тариалан, ургамлын хийгээд ойн аж ахуй, мал тэжээвэрийн аж ахуй, мал эмнэлэг зэрэг салбарын талаар эрдэмтдийн бичсэн өгүүлүүд болоод хөдөө аж ахуйн асуудлаар эрдмийн зэрэг хамгаалагсдын бүтээлийн жагсаалтаас нийтэлжээ.

Сан хөмрөгт: 1957-1970 оны дугаарууд

“Вестник сельскохозяйственной науки”-Агротехника нь Бүх холбоотын Хөдөө аж ахуйн Шинжлэх ухааны Академийн К.К. Гедройцийн нэрэмжит Бүх холбоотын Өтгө бордоо, агротехник, агро хөрс судлалын эрдэм шинжилгээ-судалгааны хүрээлэнгээс 1940 оноос эрхлэн гаргасан мэдээллийн дугаар юм. 1940 оны хоёрдугаарт ургамлын физиологийн асуудалд зориулагдсан ажээ.

Сан хөмрөгт: 1940 №1-4





“Вестник сельскохозяйственной науки”-Животноводство нь Бүх холбоотын Хөдөө аж ахуйн Шинжлэх ухааны Академийн Бүх холбоотын Мал тэжээвэрийн аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс 1940 онд эрхлэн гаргасан мэдээллийн дугаар юм. Тус дугаарт эрдэм шинжилгээ-судалгааны хүрээлэн, туршлага станц, их дээд сургуулиуд, лабораторийн ажлын дүнгээс өргөн нийтэлдэг. Мал аж ахуйгаас гадна тахиа, гахай зэрэг тэжээвэр амьтадын холбогдол бүхий судалгааг ч ихээхэн анхаардаг юм. 1940 оны нэгдүгээрт үхэр, хонины аж ахуй, тэдгээрийн судалгаанд онцгой анхаарал тавьсан ажээ.

Сан хөмрөгт: 1940 №1;4

“Вестник сельскохозяйственной науки”-Кормодобывание нь Бүх холбоотын Хөдөө аж ахуйн Шинжлэх ухааны Академийн В.Р.Вильямсийн нэрэмжит Бүх Холбоотын Тэжээлийн эрдэм шинжилгээ-судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргадаг мэдээллийн дугаар юм. Уул мэдээллийн 1940 оны тавдугаарт Билчээрийн ба хадлангийн ургамал, тэжээлийн ургамлын агротехник ба үр үржүүлгийг сайжруулах, тэжээлийн үйлдвэрлэл ба механикжуулалт зэрэг бүлэгт хамарах өгүүлэл судалгааг нийтэлжээ.

Сан хөмрөгт: 1940 №1-5; 1941 №1-3







“Вестник сельскохозяйственной науки”- Мелиорация и гидротехника нь Бүх холбоотын Хөдөө аж ахуйн Академийн Хөрс сайжруулалт, усжуулалтын техникийн эрдэм шинжилгээ-судлалын хүрээлэнгээс 1940 онд эрхлэн гаргасан мэдээлэл юм. Эл мэдээлэлд хөрс сайжруулалт, усжуулалтын эрдэм шинжилгээ-судалгааны хүрээлэн, хөрс сайжруулалтын туршлага станц, болон бусад холбогдох байгууллага, эрдэмтдийн ажлын арга туршлагыг тогтолцоотойгоор солилцуулах, ололт амжилтыг үйлдвэр аж ахуйд нэвтрүүлэхэд онцгой ач холбогдол бүхий бүтээлээс нийтэлж, олны хүртээл болгосон ажээ.

Сан хөмрөгт: 1940 №1;3

“Вестник сельскохозяйственной науки”-Механизация и электрификация нь Бүх холбоотын Хөдөө аж ахуйн Шинжлэх ухааны Академийн Бүх холбоотын Хөдөө аж ахуйн механикжуулалт, цахилгаанжуулалтын эрдэм шинжилгээ-судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргадаг мэдээлэл юм. Уг мэдээллийн 1940 оны нэгдүгээрт “Тэргүүний шинжлэх ухааны өндөр түвшин-механикжуулалтын асуудал”, “Мал, тэжээврийн аж ахуй дахь салхин хөдөлгүүрийн үүрэг”, “Хонь хяргахад зориулсан машины аппаратын судлагаа” зэрэг механикжуулалт, цахилгаанжуулалтын холбогдол бүхий өгүүллүүд нийтлэгдсэн ажээ.

Сан хөмрөгт: 1940 №1




“Вестник сельскохозяйственной науки”-Овощеводство и картофель нь Бүх холбоотын Хөдөө аж ахуйн Шинжлэх ухааны Академийн Төмсний аж ахуйн эрдэм шинжилгээ-судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргадаг мэдээлэл юм. Уг мэдээллийн 1940 оны гуравдугаарт төмс, хүнсний ногооны судалгаатай холбогдсон онол, туршлагын өгүүллүүд гол төлөв нийтлэгдсэн ажээ.

Сан хөмрөгт: 1940 №1;3

“Вестник сельскохозяйственной науки”-Плодово-ягодные культуры нь Хөдөө аж ахуйн Шинжлэх ухааны Академийн И.В.Мичурины нэрэмжит жимс жимсгэний генетикийн төв лаборатори, И.В.Мичурины нэрэмжит жимсгэний эрдэм шинжилгээ-судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргадаг мэдээлэл юм. Уг мэдээллийн 1940 оны нэгдүгээрт И.В.Мичурины зарим бүтээлээс нийтлэж, түүний сургаал жимс-жимсгэний аж ахуйн салбарт хэрхэн хэрэгжиж байгаа туршлагаас өргөн хэвлэжээ.

Сан хөмрөгт: 1940 №1-4





“Вестник сельскохозяйственной науки”-Технические культуры нь Бүх холбоотын Хөдөө аж ахуйн Академийн Бүх холбоотын эрдэм шинжилгээ-судалгааны сүүн шүүс гаргадаг модлог ургамлын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг мэдээлэл юм.1931 оноос үндэс сууриа тавьсан уг хүрээлэнгээс 1940 онд гарсан нэгдүгээр мэдээлэлдээ агротехник, физиологи, биохими, технологи, техникийн ургамал хамгааллын зэрэг салбарын онолын болон практик, туршлагын олон асуудлыг хөндсөн өгүүллүүд дээжлэн хэвлэжээ.

Сан хөмрөгт:1940№1

Ветеринария нь ЗСБНХУ-ын Ардын Комиссарын “Зема”-ийн хэвлэл, шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн сар тутмын сэтгүүл юм. Тус сэтгүүлийн дугаарууд нь Дэлхийн II дайны үед Улаан армийн дайны талбарт болон ар талд цэрэг дайчдын итгэлт хүлэг морин хийгээд мал, тэжээврийн бүхий л аж ахуйг эрүүлжүүлэх, элдэв өвчин эмгэгт нэрвэгдвээс түргэн шуурхай эдгэрүүлэхэд бүхий л эрдэмтэд, эмч нарын удирдамж, зөвлөлгөөг өргөн нийтэлдэг. Үүгээрээ Ветеринария сэтгүүл нь хэн хүнд гарын авлага болж байжээ.

Сан хөмрөгт: 1941-1984; 1986-1992

